

**МОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН ТӨСВИЙН 2022 ОНЫ ТӨСВИЙН ХҮРЭЭНИЙ
МЭДЭГДЭЛ, 2023-2024 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨӨЛЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ БОЛОН ХАМТ ӨРГӨН
МЭДҮҮЛСЭН ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ
ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙГ ЭЦСИЙН ХЭЛЭЛЦҮҮЛЭГТ БЭЛТГЭСЭН ТАЛААРХ
ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ТАНИЛЦУУЛГА**

2021 оны 11 дүгээр
сарын 10-ны өдөр

Улаанбаатар
хот

Илтгэгч нь: Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2021 оны 9 дүгээр сарын 30-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын нэгдсэн төсвийн 2022 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2023-2024 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг Улсын Их Хурлын чуулганы 2021 оны 11 дүгээр сарын 04-ний өдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлсэн.

Төсвийн байнгын хорооны 2021 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн хуралдаанаар дээрх хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг хийлгээ.

Төсвийн төслийн хоёр дахь хэлэлцүүлгээр олонхийн дэмжлэг авсан саналуудтай холбогдуулан дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн эдийн засгийн үндсэн үзүүлэлт-нэгдсэн төсвийн хөрөнгийн зардлын хэмжээ 2022 онд 81.1 тэрбум төгрөгөөр нэмэгдэхээр байгаа тул төсөлд тусгагдсан нэгдсэн төсвийн хөрөнгийн зардлын хэмжээ 2022 онд 5,116.1 тэрбум төгрөг гэснийг 5,197.1 тэрбум төгрөг гэж, дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь 2022 онд 10.9 гэснийг 11.1 гэж өөрчлөх санал гаргасныг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

Байнгын хороогоор хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг хийсэн дунд үндэслэн эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төслийг бэлтгэж, танилцуулга, санал хураалгах томьёоллын хамт Та бүхэнд тараасан болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2022 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2023-2024 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төсвийн байнгын хорооны танилцуулга, зарчмын зөрүүтэй саналын томьёоллыг хэлэлцэн, хуулийн төслүүдийг эцэслэн баталж өгнө үү.

Анхаарал тавьсанд баярлал�а.

**ТӨСВИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА -ЧХ-**

Ч.ХҮРЭЛБААТАР

